



## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 4/84

Улаанбаатар хот

### Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/116, Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр цагдаагийн байгууллагын алба хаагчдын 2017 оны хэрэгцээт дүрэмт хувцас, тусгай зориулалтын материал, ялгах тэмдгийг шууд гэрээгээр бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох ажлыг зохион байгуулах үнэлгээний гуравдугаар хороог дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсугай.

#### Үнэлгээний хорооны дарга:

- |   |   |
|---|---|
| 1. У.Энхтөр                               | Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны дарга, цагдаагийн хурандаа  |
| 2. Нарийн бичгийн дарга:<br>Д. Мөнхбаатар | Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа  |
| 3. Л. Батсүрэн<br>Гишүүд:                 | Нийслэлийн цагдаагийн газрын ерөнхий нягтлан бодогч, Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн ахлах дэслэгч                    |
| 4. Ц. Баярсайхан                          | Санхүү, аж ахуйн албаны Хангарт үйлчилгээний төвийн дарга, цагдаагийн хурандаа  |
| 5. Д. Энхбадрах                           | Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хоёрдугаар газрын Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа |
| 6. Б.Галбаатар                            | Нийтийн хэв журам хамгаалах албаны Хамгаалалтын газрын тусгай хамгаалалтын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа          |
| 7. Б.Баярсайхан                           | Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын Мэргэжил арга зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа           |

0901361

8. Г.Баялагмаа Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн хувцасны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
9. А.Ишгэрэл Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч
10. Б.Батням Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн хувцасны чанар, технологийн мэргэжилтэн
11. Х.Цогтбаатар Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах нягтлан бодогч

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах дүрэмт хувцасны нэр төрлийг хавсралтаар баталсугай.

3. Хавсралтаар батлагдсан дүрэмт хувцасны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, явц үр дүнг тухай бүр, нэгдсэн танилцуулгыг 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор илтгэхийг Үнэлгээний хорооны дарга /Цагдаагийн хурандаа У.Энхтер/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан мөн газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/71 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа П.Батбаатар/-т даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
ХУУЛБАР ҮНЭН  
Захиргааны удирдлагын газрын дарга,  
цагдаагийн хурандаа

Ө.ЭНХТӨР

П.Оростогоо



Цагдаагийн ерөнхий газрын даргын  
2017 оны 05 дугаар сарын 05-ны  
өдрийн 16 дугаар тушаалын  
хавсралт

УХГ0026

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ  
ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Хувцасны нэр төрөл
1.	Албаны мөрдэс
2.	Өдөр тутмын хар хөх цамц /урт ханцуйтай/
3.	Захгүй богино ханцуйтай цамц
4.	Өвлийн дотортой гутал
5.	Богино түрийтэй гутал
6.	Зарим төрлийн дүрэмт хувцасны ажлын үлгэр, техникийн баримт бичиг боловсруулах, материалын өнгөний кодыг тогтоох

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР